



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/564

Булган сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 230512/04-322 дүгээр гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Булган/ төсөл, арга хэмжээний 4 дүгээр багцаас нийлүүлж буй 608 толгой бог малыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Одхүү ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирал)

Гишүүд:

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Ц.Бямбацогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)


2. Тендерт шалгарсан аж ахуй нэгжтэй гэрээнд заасан хугацааны дагуу тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод нийцүүлэн 608 толгой бог малыг хүлээн авч, хууль тогтоомжийн дагуу баримт бичиг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Одхүү)-т даалгасугай.

3. Дээрх 608 толгой бог малыг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

4. Бог малыг аймгийн Засаг даргын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу сумдад нийлүүлэх, хадгалалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (Б.Одхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



0323010597